



МОНГОЛБАНК



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

## МОНГОЛ УЛСАД АЯЛЖ БУЙ ГАДААДЫН ЖУУЛЧДЫН ЗАРДЛЫН ТҮҮВЭР СУДАЛГАА<sup>1</sup>

### Хураангуй

Төлбөрийн тэнцлийн статистикт аялал жуулчлалын салбарын орлогыг тооцоход ашиглагдах гадаадын жуулчдын дундаж зардлын хэмжээг тодорхойлох зорилгоор энэхүү түүвэр судалгааг гүйцэтгэв.

Тус судалгаанд Монгол Улсад аялсан гадаадын 1233 жуулчныг санамсаргүй түүврийн аргаар сонгон хамрууллаа.<sup>2</sup> Судалгааны гол үр дүнгээс дурдахад гадаадын жуулчид Монголд дунджаар 14 хонох хугацаандаа 1,774 ам.долларыг зарцуулж байна.

2015

<sup>1</sup>Монголбанкны ВЭЗГ-ын ТТССХ-ийн эдийн засагч Б.Мөнх-Эрдэнэ, 327088,  
[bmunkherdene@mongolbank.mn](mailto:bmunkherdene@mongolbank.mn)

<sup>2</sup> Энэхүү түүвэр судалгааны мэдээллийг цуглуулсан ажилтнууд болон дэмжлэг, туслалцаа үзүүлсэн Буянт-Ухаа хилийн боомт, Чингис хаан олон улсын нисэх буудлын хамт олонд талархал илэрхийлье.

Түүвэрлэлт гүйцэтгэсэн ажилтнууд: АЖҮТ-ийн мэргэжилтэн У.Батцэцэг, АНУ-ын Калифорниагийн их сургуулийн оюутан А.Сэлэнгэ, Украин улсын УТИС-ийн оюутан Э.Ариунзул, ОХУ-ын Г.В.Плехановын нэрэмжит ЭЗИС-ийн оюутан Б.Билгүүн, Б.Уламбаясах, ХААИС-ийн оюутан Н.Амарбаатар, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн оюутан Б.Долгорсүрэн

## 1. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

### 1.1 Судалгааны зорилго

Төлбөрийн тэнцлийн аяллын данс дахь жуулчлалын салбарын орлогыг тодорхойлохдоо Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний ерөнхий газраас гаргаж буй жуулчдын тоо болон Монголбанкны 2005, 2011 онд хийсэн дундаж зардлын түүвэр судалгааны үр дүнд үндэслэж байна. Гадаад, дотоодын инфляцийн түвшин ханшийн өөрчлөлтөөс шалтгаалан дундаж зардал тогтмол өөрчлөгддөг тул энэ төрлийн түүвэр судалгааг 3-4 жил тутам тогтмол гүйцэтгэж, дундаж зардлын хэмжээг шинэчлэн тогтоох шаардлагатай байдаг. Тиймээс энэ удаагийн судалгааны ажлаар 2011 онд гүйцэтгэсэн гадаадын жуулчдын Монгол Улсад зарцуулсан дундаж зардлын хэмжээг шинэчлэн тогтоохыг зорилоо.


Мөн аялал жуулчлалын салбарын бодлогод дэмжлэг болох зорилгоор гадаадын жуулчдын Монгол Улсад аялж буй шалтгаан, сэтгэл ханамж, санал зөвлөмжийг агуулсан асуултуудыг судалгааны анкетад<sup>3</sup> нэмж оруулсан болно.

### 1.2 Түүврийн оновчтой хэмжээ

Түүврийн оновчтой хэмжээг сонгох олон аргачлал байдаг хэдий ч практикт хамгийн өргөн ашиглагддаг, түүвэрлэлтийн үндсэн таамаглал нь эх олонлогийг хэвийн тархалттай гэж үзэх, энгийн санамсаргүй түүврийн аргачлалаар түүврийн хэмжээг сонгож, томъёог доор үзүүлэв.

$$n = \frac{t^2 * w * (1 - w) * N}{N * \Delta_p^2 + t^2 * w * (1 - w)}$$

Энд,  $t$  = Студентийн  $t$  тархалтын критик утга;  $w$  = түүврийн тодорхой асуултанд хариулах магадлал буюу зорилтот бүлгийн эх олонлогт эзлэх хувь. Судалгаа хийхээс өмнө энэ үзүүлэлт мэдэгдэхгүй бол 0.5 гэсэн тогтмол хэмжээг ашигладаг;  $N$  = эх олонлогийн хэмжээ;  $\Delta$  = алдааны хязгаар буюу түүврийн үр дүнд гарсан дундаж утга нь түүврийн хэмжээг  $\Delta$  хувиар ихэсгэж, бууруулсан ч үр дүн нь ижил гарна гэсэн таамаглал.



Өгөгдөл	Утга	Тайлбар
$t$	1.96	95%-ийн итгэх магадлалын түвшин
$w$	0.5	Тогтмол утга
$N$	148,322	Эх олонлог: 1 жилд аялсан жуулчдын тоо
$\Delta$	0,05	Алдааны хязгаар
$n$	383	Оновчтой түүврийн хэмжээ

Түүврийн эх олонлогийг 2014 онд Монгол Улсад ирсэн гадаадын жуулчдын тоо болох 148,322<sup>4</sup> гэж үзэж, хамгийн бага оновчтой хэмжээг 95%-ийн итгэх магадлалтай, +/- 5%-ийн алдааны хязгаартай байхаар сонгон тооцоолоход 383 гарч байна.

### 1.3 Түүврийн хэмжээ, шинж чанар

Түүвэр судалгааны хүрээнд 2015 оны 7 дугаар сарын 6-31-ний өдрүүдэд Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал, Улаанбаатар төмөр замын буудлаас Монгол Улсад аялаад


<sup>3</sup> Судалгааны анкеттай хавсралтаас танилцана уу

<sup>4</sup> ИХШХЕГ-ын мэдээ


буцаж буй 1233 жуулчнаас анкетын аргаар мэдээлэл цуглуулсан ба түүврийн хэмжээ нь өмнө тодорхойлсон хамгийн бага оновчтой түвшин болох 383-аас их байна.

ИХШХЕГ-аас гаргадаг Монгол Улсын хилээр нэвтэрсэн гадаадын жуулчдыг улс орон, бүс нутгаар нь ангилан үзэхэд БНСУ-ын жуулчид 22%, БНХАУ 17%, ОХУ 17%, АНУ болон Канадын жуулчид 6%-ийг тус тус эзэлж байгаа бол түүвэрт хамрагдсан жуулчдын хувьд харгалзан 11%, 10%, 6%, 15%-ийг эзэлж байгаагаас үзэхэд түүврийн бүтэц нь эх олонлогийн бүтцээ төлөөлж чадахуйц харьцангуй нийцтэй тархсан байна. (Дүрслэл 1)

Дүрслэл 1. Эх олонлог болон түүврийн бүтцийн харьцуулалт<sup>5</sup>



Дүрслэл 2. Жуулчдын нас, хүйсийн бүтэц



Дүрслэл 2-т түүвэрт хамрагдсан жуулчдын нас, хүйсний бүтцийг үзүүлсэн ба нийт жуулчдын 60%-ийг эрэгтэй, 40%-ийг эмэгтэйчүүд эзлэхийн дээр бүх насны төлөөллийг хамарч чадсан байна.

Судалгааны түүврийн бүтэц нь улс орон, нас, хүйсний хувьд жигд тархсан учраас түүврийн үр дүн нь эх олонлогоо төлөөлж чадахаар байна.


<sup>5</sup> Баруун Европын бусад улсууд: Испани, Португал, Голланд, Бельги, Андор, Люксембург, Швед, Норвеги, Финлянд, Австри, Дани, Швейцарь, Итали, Лихтенштейн, Мальта, Кипр, Грек, Исланд, Ирланд  
 Өмнөд ази: Тайвань, Хонгконг, Сингапур, Малайз, Тайланд  
 Бусад улс: Израйл, Бразил, Өмнөд Африк, Энэтхэг, Турк улсын жуулчид голчлон хамрагдсан

## 2. СУДАЛГААНЫ ҮР ДҮН


### 2.1 Аяллын дундаж зардал

Гадаадын жуулчдын Монгол Улсад байх хугацаандаа буюу эдийн засгийн харьяатад зарцуулж буй дундаж зардал нь тухайн жуулчин аяллаа хэрхэн зохион байгуулсан болон аль улсын тур оператор компаниар үйлчлүүлснээс хамаарч ялгаатай байдаг нь өмнөх судалгааны ажлуудаар тогтоогдсон.

Дүрслэл 3. Асуулт: Та аяллаа хэрхэн зохион байгуулсан бэ?



Дүрслэл 4. Асуулт: Та аль улсын жуулчны компаниар үйлчлүүлсэн бэ?



Энэ удаагийн судалгаанд хамрагдсан жуулчдын 51% нь аяллаа хувиараа, бие даан зохион байгуулсан бол үлдсэн 49% нь тур оператор (тэдгээрийн 51% нь манай улсын, 49% нь гадаадын)-уудаар үйлчлүүлсэн байна. Жуулчдын дундаж зардлын хэмжээг тооцоход нийт 1,233 түүврээс математик статистикийн тооцоололд чанар хангаагүйг хасч, үлдсэн 994 түүврийг ашиглав. Жуулчид Монгол Улсад дунджаар 14 хоног аялдаг бөгөөд хувийн аялагчид 1,526 ам.доллар, багц аялагчид 2,383 ам.долларыг тус тус зарцуулдаг байна. Аялалын зардал ийнхүү 1.6 дахин ялгаатай байгаа нь жуулчлалын байгууллагын үйлчилгээний шимтгэлтэй холбоотой юм.

Хүснэгт 1. Түүврийн үр дүн, тооцоолол

	Дундаж хоног	Аяллын дундаж зардал		
		I. Хувиараа аялагчид	II. Багц аялал	
			Түүврийн үр дүн	Үүнээс, МУ-д орох орлого
Австрали, Шинэ Зеланд	14	2,040	2,401	2,048
АНУ, Канад	16	2,148	3,528	3,009
БНХАУ	13	1,622	1,688	1,440
БНСУ	9	1,549	1,834	1,565
Герман	16	1,508	2,649	2,259
Их британи	14	1,765	2,236	1,907
ОХУ	13	1,186	1,268	1,081
Франц	17	1,213	1,569	1,338
Япон	11	1,369	1,591	1,357
Баруун европ	16	1,249	2,244	1,914
Өмнөд ази	10	1,105	1,793	1,530
Бусад	15	1,487	2,828	2,412
<b>Дундаж</b>	<b>14</b>	<b>1,526</b>	<b>2,383</b>	<b>2,033</b>


**Хүснэгт 2. Монгол Улсад зарцуулж буй аяллын дундаж зардал**

	I. Хувиараа аялагчид	ii. Багц аялал	Дундаж
Австрали, Шинэ Зеланд	2,040	2,048	2,044
АНУ, Канад	2,148	3,009	2,570
БНХАУ	1,622	1,440	1,532
БНСУ	1,549	1,565	1,557
Герман	1,508	2,259	1,876
Их британи	1,765	1,907	1,835
ОХУ	1,186	1,081	1,134
Франц	1,213	1,338	1,274
Япон	1,369	1,357	1,363
Баруун европ	1,249	1,914	1,575
Өмнөд ази	1,105	1,530	1,313
Бусад	1,487	2,412	1,940
<b>Дундаж</b>	<b>1,526</b>	<b>2,033</b>	<b>1,774</b>


Монгол Улсын эдийн засгийн харьяатад төлсөн аяллын дундаж зардлыг тооцохдоо, багц аяллын нийт зардлаас гадаадын компанид ногдох ашгийг Монголбанкны 2011 оны судалгааны дагуу 30%<sup>6</sup> -иар тооцон хасахад манайд улсад үлдэх хэсэг нь 2,033 ам.доллар болж байна.

Хувийн аялагчдын зарцуулсан зардлын бүтцийг үзвэл нийт зардлын дунджаар 30%-ийг зочид буудал, байранд 24%-ийг ресторан, хоолны газарт, 20%-ийг бараа худалдан авахад зарцуулдаг байна. Харин багц аялагчдын хувьд нийт зардлынхаа 72%-ийг жуулчлалын компанид төлж байна.

**Дүрслэл 5. Хувиараа аялагчдын зардлын бүтэц**




**Дүрслэл 6. Багц аялагчдын зардлын бүтэц**



<sup>6</sup> Энэхүү коэффициентийг аялал жуулчлалын үйлчилгээ эрхэлдэг компаниудаас ярилцлагын аргаар авсан мэдээлэлд үндэслэн тогтоосон. 2005 оны судалгаанд уг коэффициентийг 70% гэж үзэж байсан ч жил ирэх тутам жуулчид интернетээр дамжуулан шууд Монголын байгууллагад хандах нь ихэссэнээс шалтгаалж энэхүү коэффициент буурсан.

### Дүрслэл 7. Асуулт: Та аялах хугацаандаа төлбөр тооцоогоо ямар хэлбэрээр хийсэн бэ?



Жуулчид Монгол Улсад аялах хугацаандаа төлбөр тооцооны дунджаар 74%-ийг бэлнээр, 26%-ийг карт ашиглан төлдөг ба энэхүү үр дүн нь дотоодын зах дах бэлэн валютын нийлүүлэлтийн тооцоо, судалгаанд эх сурвалж болон ашиглагдах ач холбогдолтой юм.

## 2.2 Өмнөх судалгааны үр дүнтэй харьцуулсан байдал

Монголбанкнаас 2011 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүнтэй харьцуулбал гадаадын жуулчдын Монгол Улсад аялахдаа зарцуулсан дундаж зардлын хэмжээ дунджаар 31%-иар өссөх байх бөгөөд энэ нь өнгөрсөн 4 жилийн инфляцийн өсөлттэй холбоотой юм. Тухайлбал, жуулчид хамгийн их ирдэг 7-р сард жилийн инфляци дунджаар 11% байсан ба үүнээс зочид буудал, нийтийн хоол 12%, тээврийн үйлчилгээ 7%, амралт, чөлөөт цаг, соёлын үйлчилгээ 2%, бусад үйлчилгээ 11%-иар тус тус өссөн байна.

Хүснэгт 3. Өмнөх судалгаануудтай харьцуулсан байдал

	2015	2011	2005	2015/2011	2015/2005
Австрали, Шинэ Зеланд	2,044	1,025	567	99%	3.6x
АНУ, Канад	2,570	1,348	958	91%	2.6x
БНСУ	1,557	797	618	95%	2.5x
Герман	1,876	2,097	844	-11%	2.2x
Их британи	1,835	1,236	850	48%	2.1x
Франц	1,274	1,529	831	-17%	1.5x
Япон	1,363	1,423	567	-4%	2.4x
Баруун европ	1,575	1,319	861	19%	1.8x
Бусад	1,940	1,372	642	41%	3.0x
БНХАУ	1,532				
ОХУ	1,134				
Өмнөд ази	1,313				
<b>Дундаж</b>	<b>1,774</b>	<b>1,350</b>	<b>749</b>	<b>31%</b>	<b>2.3x</b>

### 2.3 Жуулчдын сэтгэл ханамж

Судалгаанд оролцсон жуулчдын Монгол Улсад аялсан шалтгаан, сэтгэл ханамжийг дүгнэвэл:


Жуулчдын дийлэнхи буюу 76% нь Монголын уламжлалт зан заншил, соёл болон үзэсгэлэнт байгаль, зэрлэг ан амьтанд татагдан хүрэлцэн ирсэн байх бөгөөд манай улсын аялал жуулчлалын үйлчилгээг 13% нь маш сайн, 46% нь сайн, 20% нь хангалттай, 17% нь дунд, 4% нь муу гэж үнэлээд, улмаар нийт жуулчдын 76% нь Монгол Улсад дахин ирнэ гэсэн хариултыг өгсөн байна.

Дүрслэл 8. Асуулт: Таны МУ-ыг сонгох болсон гол шалтгаан юу вэ?




“Таны аялалд ямар зүйлсийг сайжруулбал илүү сайхан, зугаатай болох байсан бэ?” гэсэн асуултанд 40% нь буюу 490 жуулчин саналаа өгсөн бөгөөд Монгол Улсын аялал, жуулчлалын талаарх өөрсдийн сэтгэгдэл, саналыг тэмдэглүүлсэн. Үүнд, Монгол хүмүүс, үзэсгэлэнт байгаль, Монголын эртний түүхийг магтсан тэмдэглэлүүд их байна.

Дүрслэл 9. Асуулт: Та Монголын аялал жуулчлалын үйлчилгээг хэрхэн үнэлэх вэ?



Дүрслэл 10. Асуулт: Та Монгол Улсад дахин ирэх үү?



Мөн Монгол Улсын аялал, жуулчлалын үйлчилгээг хөгжүүлэхэд дараах асуудлуудыг шийдвэрлэх шаардлагатай гэсэн саналыг дийлэнхи нь өгсөн байна.

- i. *Англи хэл:* Гудамжны тэмдэг, тэмдэглэгээг англи хэл дээр бичих, таксины жолооч, үйлчилгээний ажилтнуудыг илүү сайн англи хэлтэй болгох;
- ii. *Нийтийн тээврийг сайжруулах:* Улаанбаатар хотын автобус, орон нутгийн галт тэрэг, нислэгийн хуваарь болон чиглэлүүдийн талаар жуулчдад зориулсан мэдээллийн төвийг бий болгох;
- iii. *Угаалгын өрөө, хог:* Хотод болон жуулчны баазуудын угаалгын өрөө, 00-ын өрөөнүүдийг сайжруулах, шинээр бий болгох, хогийн савнууд хангалттай байрлуулах, шүршүүрийн халуун усыг шийдвэрлэх;



- iv. *Бусад бүтээн байгуулалтын санал:* Англи хэл дээрх музейнуудыг бий болгох, сүм, хийдүүдийг засварлах, Тэрэлжийн дархан цаазат газарт жуулчдыг ууланд явган аялахад зориулсан зам бий болгох.

### 3. ДҮГНЭЛТ

Энэхүү судалгаагаар Монгол Улсад аялсан гадаадын жуулчдын дундаж зардлыг шинэчлэн тооцоолсон нь цаашид төлбөрийн тэнцэл, аялал жуулчлалын статистикийн чанарыг сайжруулах ач холбогдолтой боллоо.

Жуулчдын хувьд ирсэн улс орноосоо хамаарч зардлууд нь харилцан ялгаатай байгаа бөгөөд дунджаар 14 хоногт 1,774 ам.доллар зарцуулж байна. Энэ нь Монголбанкнаас 2011 онд гүйцэтгэсэн судалгааны үр дүнгээс 31%-иар өндөр үзүүлэлт юм.

Мөн жуулчдын 51% нь хувиараа, 49% нь жуулчны компаниар үйлчлүүлдэг ба аяллын нийт зардлынхаа 74%-ийг бэлэн мөнгөөр, 26%-ийг төлбөрийн картаар гүйцэтгэдэг байна. Олон улсын тээврээс бусад зардлынхаа хамгийн өндөр буюу 30 орчим хувийг зочид буудал, орон байранд, 24%-ийг ресторан, хоолны газарт, 20%-ийг барааны худалдаанд зарцуулдаг байна.

Түүнчлэн, Монгол Улс дахь жуулчлалын орчинг сайжруулахад гудамжны тэмдэг, нийтийн тээврийн мэдээллийн төв, музейг англи хэл дээр бий болгох, угаалгын өрөө, хогны асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байгаа жуулчдын бичсэн саналуудаас харагдаж байна.





## ХАВСРАЛТ 1. Судалгааны маягт



МОНГОЛ БАНК



АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ҮНДЭСНИЙ ТӨВ

### МОНГОЛ УЛСАД АЯЛЖ БУЙ ГАДААДЫН ЖУУЛЧДЫН СУДАЛГАА

Монголбанк болон Аялал жуулчлалын үндэсний төв хамтран Монгол улсад ирж буй гадаад жуулчдын сэтгэл ханамжийг тодорхойлох, статистик үзүүлэлтийг сайжруулах зорилгоор энэхүү түүвэр судалгааг зохион байгуулж байна.

Судалгааг бөглөхөд ойролцоогоор 1 минут зарцуулагдана. Таны өгсөн мэдээллийн нууцлалыг Статистикийн тухай Монгол Улсын хуулийн дагуу чандлан хадгалж, тайланг зөвхөн нэгтгэсэн байдлаар боловсруулах тул та үнэн зөв бөглөнө үү.

1. *Та аль улсаас ирсэн бэ?:* .....
2. *Таны нас?*

a. 19-с доош	d. 40-49
b. 20-29	e. 50-59
c. 30-39	f. 60-с дээш
3. *Таны хүйс?*

a. Эрэгтэй	b. Эмэгтэй
------------	------------
4. *Та Монгол Улсад нийт хэдэн өдөр аялсан (аялахаар төлөвлөж байна) бэ?*

a. ....	
---------	--
5. *Таны аяллын үндсэн зорилго юу вэ? /1-ээс олон хариулт сонгож болно/*

a. Амралт, аялал жуулчлал	d. Ажил эрхлэлт
b. Албан томилолт, бизнес	i. 1-ээс дээш жил
c. Боловсрол, сургалт	ii. 1-ээс доош жил
i. 1-ээс дээш жил	e. Бусад ..... /бичнэ үү/
ii. 1-ээс доош жил	
6. *Таны Монгол Улсыг сонгон айлчлах болсон гол шалтгаан юу вэ?*

a. Үзэсгэлэнт байгаль, зэрлэг ан амьтан	c. Монголын түүх
b. Монголын уламжлалт зан заншил, соёл	d. Адал явдалт аялал
	e. Бусад: .....
7. *Та Монголын аялал жуулчлалын үйлчилгээг ерөнхийд нь хэрхэн үнэлэх вэ?*

a. Муу	d. Сайн
b. Дунд	e. Маш сайн
c. Хангалттай	
8. *Та дахин Монголд ирэх үү?*

a. Тийм, удахгүй.	c. Ирэхгүй байх.
b. Тийм, хэдэн жилийн дараа.	d. Хэзээ ч үгүй.

**9. Та аяллаа хэрхэн зохион байгуулсан бэ?**

- a. Аялалын компаниар зуучлуулсан
- b. Аяллаа өөрөө зохион байгуулсан (10-р асуултыг алгасна уу)

**10. Та аль улсын жуулчны компаниар үйлчлүүлсэн бэ?**

- a. Монгол улсын
- b. Бусад улсын

**11. Та Монгол Улсад аялах хугацаандаа зөвхөн өөртөө зориулж зарцуулсан зардлын нийт дүнг бөглөнө үү (ОУ-ын нислэг, тээврийг оролцуулахгүй)**

**Total USD .....**

Үүнээс:

1. Жуулчны компанид төлсөн багц аялалын төлбөр (та 9.b-г сонгосон бол алгасна уу)	USD .....
2. Барааны худалдаа	USD .....
3. Дотоодын тээврийн хэрэгсэл	USD .....
4. Зочид буудал, байр	USD .....
5. Ресторан, хоол, хүнс	USD .....
6. Бусад үйлчилгээ /бичнэ үү: .....	USD .....

**12. Та Монгол Улсад аялах хугацаандаа төлбөр тооцоогоо ямар хэлбэрээр хийсэн бэ? (хувиар бичнэ үү)**

- ❖ ОУ-ын картаар ..... %-ийг
- ❖ Бэлнээр ..... %-ийг

**13. Таны аялалд ямар зүйлийг сайжруулвал илүү сайхан, эсвэл илүү зугаатай болгож болох байсан бэ?**

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

.....

**СУДАЛГАА ӨГСӨН ТАНЬД БАЯРЛАЛАА  
САЙХАН АЯЛААРАЙ**

**THE BANK OF MONGOLIA**  
Baga toiruu-3, 15160, Ulaanbaatar-46,  
Mongolia  
Tel: 976-11-310605; Fax: 976-11-311471  
E-mail: [info@mongolbank.mn](mailto:info@mongolbank.mn);  
[bop@mongolbank.mn](mailto:bop@mongolbank.mn)  
[www.mongolbank.mn](http://www.mongolbank.mn)



**MONGOLIAN NATIONAL TOURISM  
CENTER**